

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 04 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар		Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7
Засгийн газрын тогтоол						
1	1 (3)	5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасгай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	Байгууллагын гаднах хаяг, туг, байгууллагад ашиглаж буй 1 тамга, 1 тэмдэг, боомт, орон нутаг дахь нэгж тус бүрийн албаны байрны гаднах хаяг, тэмдэг, албан хаагчдын ялгах тэмдэг (жетон, ханцуй, малгайн бэлгэ, тэмдэг)-т үндэсний бичгийг оролцуулсан.  Төрийн албан хаагчид зориулан Удирдлагын академиас зохион байгуулж буй 40 цагийн монгол бичгийн сургалтын “Монгол бичгийн анхан шатны 1 дүгээр шатны сургалт”-д 1 дүгээр улиралд 52 албан хаагч хамрагдаж, цахим гэрчилгээтэй дүүргэв.	100	

1	2	3	4	5	6	7
		байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
2	2 (25)	2.Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах хавсралтад дурдсан улсын иргэдийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсүгэй. 2.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай.	Визийн шаардлагаас чөлөөлөх тухай 2023-01-04 Дугаар 2023_1	Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалтад багтаж байсан Европын улсууд болон Австрали, Шинэ Зеланд зэрэг 34 улсын иргэнийг визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээс дээрх 34 улсыг хасаж, шийдвэрийг мөрдөн ажиллаж байна.	Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай	
3	3 (32)	Х-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49	Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах хүрээнд Монгол Улсын виз олгох үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор Гадаадын иргэн, харьяатын газраас олгодог бүх ангиллын визийн зөвшөөрлийг бүрэн цахимжуулсан.	100	
4	4 (64)	2.Монгол Улсад үйл ажиллагаа хэрэгжүүлэх Монгол-Оросын хамтарсан сургуулийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах, Оросын Холбооны Улсаас ирж ажиллах багш нарт оршин суух зөвшөөрөл олгох, аюулгүй байдлыг хангах зохих арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт	Хамтарсан сургууль байгуулах тухай 2023-08-30 Дугаар 2023_320	Монгол Улсад үйл ажиллагаа хэрэгжүүлэх Монгол-Оросын хамтарсан сургуулийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу ЗГ-ын 2023 оны 320 дугаар тогтоолоор Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 162 дугаар сургуулийг Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу "Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургууль" болгон өөрчлөн байгуулагдсан. Тайлант хугацаанд тус сургуульд ажиллах Оросын Холбооны Улсын 1 иргэнд Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгосон байна.	100	

1	2	3	4	5	6	7
		тус тус даалгасугай				
5	5 (81)	3.. 3.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.	Журам, жагсаалт, үнийн дүн батлах тухай 2023-12-13 Дугаар 2023_445	Тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ын 2.6-д заасан мэдээллийг илгээх зорилгоор 4 төрлийн сервисийг хөгжүүлэн Татварын ерөнхий газарт хүлээлгэн өгч, Төрийн мэдээлэл солилцооны ХУР системийг ашиглан мэдээлэл солилцож байна. Үүнд:  1. FS100101_personInfo (Гадаад иргэний мэдээлэл)-г 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр, 2. FS100102_registerInfo (Гадаад иргэний бүртгэлийн мэдээлэл)-г 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр, 3. FS100108_visalInfo (Гадаадын иргэний визийн мэдээлэл)-г 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, 4. FS100110_nonGovernmentalOrganizationInfo (Салбар, төлөөлөгчийн газрын мэдээлэл)-г 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр тус тус хөгжүүлэн ашиглаж эхэлсэн.  2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгож эхлэн энэ оны 03 дугаар сарын байдлаар нийт 663,118 гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгосон байна.	100	
Хэсгийн дундаж: 100 хувь						
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
6	6 (143)	II..Тогтоол батлагдсантай холбогдуулан “Монгол Улсын визийг цахимаар авах улсын жагсаалт”-д өөрчлөлт оруулах, гадаадын бусад улсыг нэмж хамруулах асуудлыг холбогдох байгууллагын саналыг харгалзан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд	2023 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр 1 дүгээр тэмдэглэл 2023-01-04 Дугаар	Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор зарим улсын иргэнийг визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn) дэх бүртгэлээс хавсралтад дурдсан 34 улсыг хасаж, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/09, А/53 дугаар хамтарсан тушаалаар 98 улсыг цахим виз	100	

1	2	3	4	5	6	7
		Б.Батцэцэг нарт даалгав.	2023_1	<p>олгох улсын жагсаалтад нэмснийг уг системд бүрэн нэвтрүүлж, нийт 99 улсын иргэнд цахим визийг олгож болохоор зохицуулсан.</p> <p>Дээрх тушаалын хавсралтаар баталсан “Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалт”-д Индонези Улсыг нэмэх саналыг 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/13 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн ба Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Жагсаалтад нэмэлт оруулах тухай” А/03, А/08 дугаар хамтарсан тушаалаар Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалтад Индонези Улсыг нэмлээ.</p>		
	7 (144)	И.З.Тогтоол батлагдсантай холбогдуулан гадаадын иргэдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар) нарт даалгав.		<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоол болон Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/09, А/53, 2024 оны А/03, А/08 дугаар хамтарсан тушаалыг тус тус мөрдөн ажиллаж, тайлант онд “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээр нийт 11004 гадаадын иргэнд цахим виз олгосноос 5612 цахим визийг 03 дугаар сард олгосон байна.</p> <p><a href="https://www.evisa.mn/en">https://www.evisa.mn/en</a></p>	100	
7	8 (156)	1.2.5. Иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд дараах асуудлыг хэлэлцэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт: -Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах замаар харилцан нийгмийн даатгалаас чөлөөлөх хугацааг нэмэгдүүлэх,	2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9	<p>Засгийн газрын 2023 оны “Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай” 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын албаны даргатай 12 дугаар сарын 15-ны өдөр, 01 дүгээр сарын 19-ний өдөр Сөүл хотноо тус тус албан уулзалт хийсэн.</p> <p>Уулзалтаар иргэд харилцан адил байх зарчмыг баримтлан Бүгд Найрамдах Солонгос Улсын хил нэвтрүүлэлгүй буцааж байгаа Монгол Улсын иргэдэд</p>	70	

1	2	3	4	5	6	7
		<p>төлөгдсөн нийгмийн даатгалын буцаан олголтод хамаарах визийн ангилал хүрээг нэмэгдүүлэх;          -БНСУ-д эмчилгээ хийлгэж буй иргэдийг дэмжих зорилгоор тус улсын эмнэлгүүдийн төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлэх болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах;          - Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн эцэг, эх, үр хүүхэд, гэр бүлийн зүгээс тус улсад зорчих виз хүсэхэд тодорхой хөнгөлөлт эдлүүлэх.</p>		<p>нааштай хандах, Монгол Улсын иргэдийг Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж буй өршөөлийн аянд хамруулан нутаг буцаах, тус улсыг сайн дураар орхин гарсан иргэнд дахин хууль ёсоор зорчих баталгааг гаргах, Монгол Улсад Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын байгууллагын төлөөллийг томилуулан ажиллуулах зэрэг саналыг дэвшүүллээ.</p> <p>Мөн байгууллагын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин зөвлөхтэй 02 дугаар сарын 22-ны уулзаж, тодорхой шаардлага хангасан болон олон удаагийн виз авах болзол хангасан иргэнд визийн хянан шийдвэрлэх хугацааг богиносгож 7-14 хоногт багтаан шийдвэрлэж байх талаар хүсэлт гаргасан.</p>		
8	9 (179)	<p>ХҮИИ.8.3. Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод төрийн үйлчилгээний цэгийг нээхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт.</p>	<p>2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03 Дугаар 2023_19</p>	<p>Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар нь Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар төмөр замын боомтын төрийн нэг цэгийн үйлчилгээний цогцолборт 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн.</p> <p>Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор “Зорчигчийн мэдээллийн төв”-ийг Хил хамгаалах ерөнхий газрын дэргэд байгуулж, “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам” батлагдсанаар байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Б/319 дүгээр тушаалаар Агаарын замын боомт хариуцсан газрын хяналтын улсын 1 байцаагчийг тус төвд томилон ажиллуулж байна.</p>	100	
Хэсгийн дундаж: 92.5 хувь						
Нийт дундаж: 96.25 хувь						